



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

**Баримт нягтлан шалгах комиссыг
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалт, 25 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, “Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Байгууллагын “Баримт нягтлан шалгах комисс”-ын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн байгуулсугай.

2. Хуульд заасан чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг жил тутам батлуулж, үйл ажиллагааг тайлагнан ажиллахыг Баримт нягтлан шалгах комисс (М.Мөнхбаяр)-т даалгасугай.

3. Архивын болон комиссын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай зардлыг гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Г.Эрдэнэцэцэг)-д зөвшөөрсүгэй.


4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2023 оны А/05 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны ...03 дугаар сарын ...17... өдрийн
А/19 дугаар тушаалын хавсралт



Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга:	М.Мөнхбаяр	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Т.Оюунтуул	Өмчийн менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Чулуунтөгс	Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Цолмон	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	С.Онон	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Санхүү бүртгэлийн ажилтан
	Б.Оюунтуяа	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Бичиг хэргийн ажилтан
Нарийн бичгийн дарга:	Ц.Болормаа	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Архивын ажилтан